

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Зардлын талаар	10
3.2	Зардлын талаар	10
3.3	Зардлын талаар	11
3.4	Зардлын талаар	11
3.5	Зардлын талаар	12
3.6	Авлага, өглөгийн тооцооны талаар.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
5	Хавсралт.....	22
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1 Аудитын гэрчилгээ

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Ж.БАТСУУРЬ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Нийт 41.2 сая төгрөгийн авлага, 0.5 сая төгрөгийн өглөгийг тус бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 13.4 сая төгрөг, шууд зардлаар 0.4 сая төгрөг, гарын үсгийн бүрдэл дутуу 0.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого болох 0.9 сая төгрөгийг авлагаар тусгаагүй, 1.0 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус зөвлөлийн дарга Ж.Батсуурь Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-наас 2019 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/175 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан

үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь Монгол Улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай, явуулах нөхцөлийг бүрдүүлэн, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй үйлчилгээг хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тус зөвлөл нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд 2018 онд нийт 48 ажил хийхээр төлөвлөснөөс 47 ажлыг гүйцэтгэж, 1 ажил дуусаагүй буюу 40 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажил, үйлчилгээний талаар
 - 1.1. Салбарын тогтвортой, үр ашигтай үйл ажиллагааг хангах;
 - 1.2. Баталгаатай, аюулгүй ус хангамжийн үйлчилгээг зохицуулах;
 - 1.3. Байгальд ээлтэй, баталгаат ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг зохицуулах;
2. Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалах ухаалаг зохицуулалт хийх;
3. Хэрэглэгчээ дээдэлсэн нийгмийн хариуцлагатай хангагч байгууллагыг төлөвшүүлэх;
4. Мэдээллийн урсгалын зөв, оновчтой зохион байгуулах;
5. Мэдлэгт суурилсан судалгаа, шинжилгээ хийх;
6. Зохицуулах зөвлөлийг бэхжүүлэх, зохицуулалтын бие даасан, хараат бус байдлыг хангах;
7. Мэдээллийн ил тод байдлыг хангах;

Зохицуулах зөвлөлийн ажлын албадын 2018 онд хийхээр төлөвлөсөн үйл ажиллагааны гүйцэтгэлийг дурдвал:

1. Тусгай зөвшөөрлийн алба 40 ажил хийхээр төлөвлөснөөс 40 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
2. Үнэ тарифын алба 23 ажил хийхээр төлөвлөснөөс 22 ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэл 95.7 хувьтай байна.
3. Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба 22 ажил хийхээр төлөвлөснөөс 22 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolum” програм хангамж ашигладаг байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг суурь үзүүлэлт болгон 1 хувиар тооцов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 670.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 6.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцсон болно. Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	17.6	
2	Албан шаардлага өгсөн	3	168.0	
	Дүн	9	185.6	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Нийт 41.2 сая төгрөгийн авлага, 0.5 сая төгрөгийн өглөгийг тус бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулж байх талаар албан шаардлага өгөв.

- Нийт 2.2 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Үүнд тус зөвлөлийн даргын 2018 оны А/62 дугаар тушаалын үндэслэл алдаатай, автомашины торгуульд нийт 1.6 сая төгрөг, 2018 оны 18/12 дугаартай санхүүгийн тайлан гаргах тухай гэрээ байгуулан 0.2 сая төгрөг, АНУ-ын Сиатл хотод сургалтанд оролцох тухай тус зөвлөлийн даргын 2018 оны А/12 дугаар тушаал гарсан боловч тушаалаар олгосон мөнгийг буцаан тушааж визний зардал болох 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна" мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

- Тус зөвлөл нь үйл ажиллагааны 2018 оны батлагдсан төсөвгүй 124.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үйл ажиллагааны 2018 оны төсвийг Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны 107 дугаар тогтоолоор батлуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус зөвлөлийн 2018 оны цалин, түрээсийн гэрээ, орлогын төлөвлөгөөний талаарх тооцоолол зэргийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Засгийн газрын 2018 оны 280 дугаар тогтоолоор тус зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 684.1 сая төгрөгөөр, зардлын төлөвлөгөөг 774.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Зардлын нийт гүйцэтгэл 676.8 сая төгрөг буюу 87.4 хувьтай байгаа нь Батлагдсан төсөвт багтаан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 349.3 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 40.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 52.6 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардал 33.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсвийг 97.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 684.1 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 670.9 сая төгрөг буюу 13.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого, хүүгийн орлогын төлөвлөгөөгүй боловч гүйцэтгэлээр нийт 5.9 сая төгрөгийн орлого олсон байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тухай бүрт нь оруулах мэдээлэл цэсэнд 8, Сар бүр оруулах мэдээлэл цэсэнд 2, улирал бүр оруулах мэдээлэл цэсэнд 1, хагас жилээр оруулах мэдээлэл цэсэнд 3, бүтэн жилээр оруулах мэдээлэл цэсэнд 9 мэдээлэл нийт 139 мэдээллийг нөхөн оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус зөвлөл нь өмнөх онд Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд аудитын түүвэрт хамрагдаж байсан учир тус албанд өгсөн албан шаардлагыг 80.0 хувьтай биелүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын талаар

3.1.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 13.4 сая төгрөг, шууд зардлаар 0.4 сая төгрөг, гарын үсгийн бүрдэл дутуу 0.3 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 20 дугаар зүйлийн 20.1.3-т "Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах" гэж заасныг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардлын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Нийт 0.4 сая төгрөгийн 2 төрлийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1-д заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Зардлын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Бэлэг дурсгалд зориулж 0.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд заасныг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Зардлын талаар

3.4.1 Илрүүлэлт:

"Эржиган булаг" ХХК-тай 2017 оны 03 дугаартай түрээсийн гэрээний төлбөрийг 0.2 сая төгрөгөөр дутуу олгосон ба өглөг үүсгээгүй тус компанитай гэрээ дүгнэсэн акт, тэмдэглэл, тооцоо нийлсэн актгүй байна. Мөн "Эмон" ХХК-тай 2017 оны 01 дугаартай түрээсийн гэрээний төлбөрийг 0.2 сая төгрөгөөр дутуу олгосон өглөг үүсгээгүй тус компанитай гэрээ дүгнэсэн акт, тэмдэглэл, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5 Зардлын талаар

3.5.1 Илрүүлэлт:

"Шаргал Угалз" ХХК-тай 2018 оны 18/07 дугаартай хөшиг худалдан авах гэрээ хийсэн боловч гэрээний үнийн дүнгээс 0.1 сая төгрөг илүү шилжүүлсэн нэр бүхий 2 байгууллагатай хийсэн гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах тус гэрээг дүгнэсэн акт, тэмдэглэл үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах аливаа гэрээг дүгнэж баталгаажуулж байх, холбогдох тэмдэглэл акт үйлдэж байх гэрээний хугацааг болон холбогдох заалтуудыг хэрэгжүүлж байх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6 Авлага, өглөгийн тооцооны талаар

3.6.1 Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлого болох 0.9 сая төгрөгийг авлагаар тусгаагүй, 1.0 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан үүсэх.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	251,531,730.99	276,805,120.54
МӨНГӨН ХӨРӨНГӨ	219,157,640.18	172,175,935.99
Кассанд байгаа бэлэн мөнгө	514,156.80	71,028.63
Касс арилжааны банк	514,156.80	71,028.63
Банкинд байгаа бэлэн мөнгө	218,643,483.38	172,104,907.36
Төгрөг	218,643,483.38	172,104,907.36
Арилжааны банк дахь харилцах	218,643,483.38	172,104,907.36
АВЛАГА	30,276,640.40	95,547,010.92
Бусад авлага	30,276,640.40	95,547,010.92
Байгууллагаас авах авлага	30,276,640.40	95,547,010.92
БАРАА МАТЕРИАЛ	2,097,450.41	9,082,173.63
Түүхий эд материал	463,650.00	412,893.00
Тусгай зориулалттай материал	463,650.00	412,893.00
Хангамжийн материал	1,633,800.41	8,669,280.63
Бичиг хэргийн материал	1,323,845.00	2,737,244.40
Аж ахуйн материал	81,512.00	3,791,133.00
Түлш, шатах тослох материал	211,474.01	1,890,903.23
Бусад хангамжийн материал	16,969.40	250,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	99,186,623.15	99,504,215.21
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	99,186,623.15	99,504,215.21
Биет хөрөнгө	75,119,405.85	83,054,375.13
Авто-тээврийн хэрэгсэл	75,400,000.00	75,400,000.00
Хуримтлагдсан элэгдэл	27,452,499.86	34,992,499.82
Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,276,849.00	62,893,049.00
Хуримтлагдсан элэгдэл	45,373,652.84	48,559,698.80
Тавилга, аж ахуйн эд хогшил	42,733,650.00	51,017,450.00
Хуримтлагдсан элэгдэл	20,388,263.60	24,613,665.25
Бусад үндсэн хөрөнгө	869,990.00	869,990.00
Хуримтлагдсан элэгдэл	149,416.85	163,000.00
Ном	1,202,750.00	1,202,750.00
Биет бус хөрөнгө	24,067,217.30	16,449,840.08
Програм хангамж	31,834,920.00	31,834,920.00
Хуримтлагдсан элэгдэл	7,767,702.70	15,385,079.92
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	350,718,354.14	376,309,335.75
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	507,646.65
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	507,646.65
Өглөг	-	507,646.65
Ажилчидтай холбогдсон өглөг	-	107,646.65
Бусад өглөг	-	400,000.00
Байгууллагад төлөх өглөг	-	400,000.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	350,718,354.14	375,801,689.10
Засгийн газрын хувь оролцоо	350,718,354.14	375,801,689.10
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,000.00	20,000.00
Өмч: - төрийн	20,000.00	20,000.00
Хуримтлагдсан үр дүн	350,698,354.14	375,781,689.10
Өмнөх үеийн үр дүн	350,698,354.14	350,698,354.14
Тайлант үеийн үр дүн	-	25,083,334.96
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	350,718,354.14	376,309,335.75

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	665,506,037.56	695,241,973.68
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	557,461,075.56	695,241,973.68
Нийтлэг татварын бус орлого	557,461,075.56	695,241,973.68
Хүүгийн орлого	3,814,072.24	5,208,232.91
Төсөв байгууллагын өөрийн орлого	553,647,003.32	690,033,740.77
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	553,507,003.32	689,451,047.54
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	267,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		315,693.23
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	108,044,962.00	-
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	108,044,962.00	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	108,044,962.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	670,813,312.61	670,158,638.72
УРСГАЛ ЗАРДАЛ	670,813,312.61	604,060,620.72
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,266,113.61	588,774,220.72
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,258,815.70	348,432,815.67
Үндсэн цалин	269,058,815.70	322,927,265.67
Гэрээт ажлын хөлс	24,200,000.00	25,505,550.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,703,071.79	40,512,706.19
Тэтгэврийн даатгал	19,203,088.75	27,298,976.62
Тэтгэмжийн даатгал	3,291,038.28	3,395,131.67
ҮОМШӨ-ний даатгал	2,341,227.42	2,716,105.74
Ажилгүйдлийн даатгал	533,428.85	645,680.29
Эрүүл мэндийн даатгал	5,334,288.49	6,456,811.87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,025,000.00	52,642,000.00
Байрны түрээс	65,025,000.00	52,642,000.00
Хангамж, бараа материалын зардал	19,364,970.37	24,315,659.14
Бичиг хэрэг	4,716,808.00	5,410,906.00
Тээвэр, шатахуун	8,005,912.00	6,248,063.78
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,509,570.37	7,232,608.36
Ном, хэвлэл	306,400.00	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	826,280.00	5,424,081.00
Нормативт зардал	903,979.00	-
Хоол, хүнс	903,979.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	2,556,900.00	6,616,200.00
Багаж, техник, хэрэгсэл	426,000.00	
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	226,000.00	
Урсгал засвар	1,904,900.00	6,616,200.00
Томилолт, зочны зардал	36,679,625.20	44,280,000.73
Гадаад албан томилолт	32,565,022.20	37,483,874.50
Дотоод албан томилолт	4,114,603.00	6,796,126.23
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,270,212.79	4,114,967.80

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	121,391,730.59	1,699,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	328,212.00	-
Даатгалын үйлчилгээ	1,588,020.00	1,479,270.00
Тээврийн хэрэгслийн татвар	166,311.00	171,811.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	54,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	
Газрын төлбөр		
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	431,939.20	273,686.80
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		437,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал	58,503,538.76	67,859,871.19
Бараа үйлчилгээний бусад зардал		54,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,557,683.00	45,223,463.25
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,945,855.76	22,582,407.94
ТАТААС	6,040,000.00	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,040,000.00	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,040,000.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,507,199.00	15,286,400.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	18,261,385.00	3,495,671.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг		
Засгийн газрын гадаад шилжүүлэг	18,261,385.00	3,495,671.00
Бусад урсгал шилжүүлэг	15,245,814.00	11,790,729.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,245,814.00	11,790,729.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	66,098,018.00
Дотоод эх үүсвэрээр		66,098,018.00
Их засвар		66,098,018.00
Гадаад эх үүсвэрээр		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(5,307,275.05)</u>	<u>25,083,334.96</u>
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(5,307,275.05)</u>	<u>25,083,334.96</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	206,839,416.60	676,805,909.93
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	206,877,446.60	676,805,909.93
Нийтлэг татварын бус орлого	206,877,446.60	676,805,909.93
Хүүгийн орлого	1,307,020.23	5,208,232.91
Төсөв байгууллагын өөрийн орлого	205,570,426.37	671,597,677.02
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,530,426.37	670,930,677.02
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.00	667,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	- 38,030.00	-
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	- 38,030.00	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	- 38,030.00	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	351,282,841.96	634,649,076.12
УРСГАЛ ЗАРДАЛ	351,282,841.96	634,649,076.12
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333,377,159.96	618,681,475.12
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,062,914.63	349,321,130.68
Үндсэн цалин	141,554,875.93	260,335,718.68
Нэмэгдэл	4,511,678.70	36,133,662.00
Унаа хоолны хөнгөлөлт	10,633,360.00	26,571,200.00
Урамшуулал	12,163,000.00	
Гэрээт ажлын хөлс	13,200,000.00	26,280,550.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,279,363.00	40,566,744.53
Тэтгэврийн даатгал	11,949,053.26	29,723,902.28
Тэтгэмжийн даатгал	1,638,977.53	2,802,409.19
ҮОМШӨ-ний даатгал	1,335,879.91	2,241,927.94
Ажилгүйдлийн даатгал	270,132.07	527,136.20
Эрүүл мэндийн даатгал	3,085,320.23	5,271,368.92
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,681,500.00	52,642,000.00
Байрны түрээс	45,681,500.00	52,642,000.00
Хангамж, бараа материалын зардал	12,297,776.73	23,570,659.36
Бичиг хэрэг	2,870,090.00	5,731,114.00
Тээвэр, шатахуун	5,573,700.00	7,662,500.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,120,826.73	7,370,608.36
Ном, хэвлэл	120,400.00	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	612,760.00	2,806,437.00
Нормативт зардал	643,529.00	-
Хоол, хүнс	643,529.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	1,554,400.00	10,829,605.00
Багаж, техник, хэрэгсэл	361,000.00	2,659,305.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	226,000.00	
Урсгал засвар	967,400.00	8,170,300.00
Томилолт, зочны зардал	5,719,113.00	44,798,278.50
Гадаад албан томилолт	3,930,441.00	37,807,852.50
Дотоод албан томилолт	1,788,672.00	6,990,426.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,941,693.60	2,525,267.80
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,906,922.00	-
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	188,512.00	-
Даатгалын үйлчилгээ	98,010.00	1,479,270.00
Тээврийн хэрэгслийн татвар	196,311.00	151,811.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний	209,938.60	447,686.80

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

хураамж		
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		402,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,196,870.00	94,427,789.25
Бараа үйлчилгээний бусад зардал		7,710,353.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,196,870.00	86,717,436.25
ТАТААС	2,000,000.00	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,000,000.00	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,000,000.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,905,682.00	15,967,601.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,079,000.00	3,495,671.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг	5,079,000.00	3,495,671.00
Бусад урсгал шилжүүлэг	10,826,682.00	12,471,930.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,826,682.00	12,471,930.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	- 144,443,425.36	42,156,833.81
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,278,920.00	89,138,538.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,278,920.00	89,138,538.00
Дотоод эх үүсвэрээр	10,278,920.00	89,138,538.00
Их засвар		66,238,538.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,278,920.00	22,900,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	- 10,278,920.00	- 89,138,538.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-154,722,345.36	-46,981,704.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	204,178,924.63	219,157,640.18
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,456,579.27	172,175,935.99

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00		271,304,623.39		271,324,623.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	0.00	271,304,623.39	0.00	271,324,623.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн			79,393,730.75		79,393,730.75
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	0.00	350,698,354.14	0.00	350,718,354.14
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	0.00	350,698,354.14	0.00	350,718,354.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	0.00	350,698,354.14	0.00	350,718,354.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
Тайлант үеийн үр дүн			25,083,334.96		25,083,334.96
2018 оны 06-р сарын 30-нээрх үлдэгдэл	20,000.00	0.00	375,781,689.10	0.00	375,801,689.10

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	774,612,000.00	723,787,614.12	50,824,385.88	93.4
УРСГАЛ ЗАРДАЛ	708,103,600.00	657,549,076.12	50,554,523.88	92.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	689,243,600.00	641,581,475.12	47,662,124.88	93.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,112,000.00	349,321,130.68	35,790,869.32	90.7
Үндсэн цалин	273,600,000.00	260,335,718.68	13,264,281.32	95.2
Нэмэгдэл	47,800,000.00	36,133,662.00	11,666,338.00	75.6
Унаа хоолны хөнгөлөлт	37,312,000.00	26,571,200.00	10,740,800.00	71.2
Гэрээт ажлын хөлс	26,400,000.00	26,280,550.00	119,450.00	99.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,213,400.00	40,566,744.53	5,646,655.47	87.8
Тэтгэврийн даатгал	30,808,960.00	29,723,902.28	1,085,057.72	96.5
Тэтгэмжийн даатгал	3,851,112.00	2,802,409.19	1,048,702.81	72.8
ҮОМШӨ-ний даатгал	3,080,900.00	2,241,927.94	838,972.06	72.8
Ажилгүйдлийн даатгал	770,224.00	527,136.20	243,087.80	68.4
Эрүүл мэндийн даатгал	7,702,204.00	5,271,368.92	2,430,835.08	68.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,250,000.00	52,642,000.00	608,000.00	98.9
Байрны түрээс	53,250,000.00	52,642,000.00	608,000.00	98.9
Хангамж, бараа материалын зардал	24,517,000.00	23,820,659.36	696,340.64	97.2
Бичиг хэрэг	5,722,000.00	5,731,114.00	9,114.00	100.2
Тээвэр, шатахуун	7,943,100.00	7,662,500.00	280,600.00	96.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,521,600.00	7,370,608.36	150,991.64	98.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,330,300.00	3,056,437.00	273,863.00	91.8
Эд хогшил, урсгал засварын зардал	32,126,700.00	33,479,605.00	1,352,905.00	104.2
Багаж, техник, хэрэгсэл	11,619,600.00	13,609,405.00	1,989,805.00	117.1
Тавилга	11,891,100.00	11,699,900.00	191,200.00	98.4
Урсгал засвар	8,616,000.00	8,170,300.00	445,700.00	94.8
Томилолт, зочны зардал	47,664,000.00	44,798,278.50	2,865,721.50	94.0
Гадаад албан томилолт	40,420,000.00	37,807,852.50	2,612,147.50	93.5
Дотоод албан томилолт	7,244,000.00	6,990,426.00	253,574.00	96.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,688,000.00	2,525,267.80	3,162,732.20	44.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00		2,500,000.00	
Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,479,270.00	320,730.00	82.2
Тээврийн хэрэгслийн татвар	170,000.00	151,811.00	18,189.00	89.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	480,000.00	447,686.80	32,313.20	93.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	694,000.00	402,500.00	291,500.00	58.0
Бараа үйлчилгээний бусад зардал	94,672,500.00	94,427,789.25	244,710.75	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	7,822,000.00	7,710,353.00	111,647.00	98.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	86,850,500.00	86,717,436.25	133,063.75	99.8

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

хийх				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,860,000.00	15,967,601.00	2,892,399.00	84.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,180,000.00	3,495,671.00	-	109.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,180,000.00	3,495,671.00	315,671.00	-
Бусад урсгал шилжүүлэг	15,680,000.00	12,471,930.00	3,208,070.00	79.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,680,000.00	12,471,930.00	3,208,070.00	79.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,508,400.00	66,238,538.00	269,862.00	99.6
Дотоод эх үүсвэрээр	66,508,400.00	66,238,538.00	269,862.00	99.6
Их засвар	66,508,400.00	66,238,538.00	269,862.00	99.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	774,612,000.00	676,805,909.93	97,806,090.07	87.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	774,612,000.00	676,805,909.93	97,806,090.07	87.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	774,612,000.00	670,930,677.02	103,681,322.98	86.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		667,000.00	-	667,000.00
Хүүгийн орлогоос санхүүжих		5,208,232.91	-	5,208,232.91
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		219,157,640.18	-	219,157,640.18
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		172,175,935.99	-	172,175,935.99
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1	-	1
Төсвөөс гадуур байгууллага		1	-	1
АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	18	2	90.0
Удирдах ажилтан	4	4	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	13	11	2	84.6
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:		2018 он		Аудитын нэр:		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит		Аудитын код:		САГ-2019/142/14-ТӨҮГ	
Шалгагдсан байгууллагын нэр:			Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл						сая төгрөгөөр		
№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны			
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр		
A	1	2	3	4	5			9	10		
1	Зардал	1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу 13.4 сая төгрөг, шууд зардлаар 0.4 сая төгрөг, гарын үсгийн бүрдэл дутуу 0.3 төгрөгийг тус тус зарцуулсан байна.	14.1	Зөвлөмж өгсөн	2019.03.15	2019.03.15	1. Дарга /хуучин/ 2. Дарга 3. Нягтлан бодогч /хуучин/ 4. Нягтлан бодогч	1. Э.Пүрэвжав 2. Ж.Батсуурь 3. Ч.Саранхүү 4. Д.Сэлэнгэ		
2	Зардал	2	Нийт 0.4 сая төгрөгийн 2 төрлийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.	0.4	Зөвлөмж өгсөн	2019.03.15	2019.03.15	Нягтлан бодогч /хуучин/	Ч.Саранхүү		
3	Зардал	3	Бэлэг дурсгалд зориулж 0.7 сая төгрөгийг зарцуулсан байна.	0.7	Зөвлөмж өгсөн	2019.03.15	2019.03.15	Нягтлан бодогч /хуучин/	Ч.Саранхүү		
4	Зардал	4	"Эржиган булаг" ХХК-тай 2017 оны 03 дугаартай түрээсийн гэрээний төлбөрийг 0.2 сая төгрөгөөр дутуу олгосон ба өглөг үүсгээгүй тус компанитай гэрээ дүгнэсэн акт, тэмдэглэл, тооцоо нийлсэн актгүй байна. Мөн "Эмон" ХХК-тай 2017 оны 01 дугаартай түрээсийн гэрээний төлбөрийг 0.2 сая төгрөгөөр дутуу олгосон өглөг үүсгээгүй тус компанитай гэрээ дүгнэсэн акт, тэмдэглэл, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.	0.4	Зөвлөмж өгсөн	2019.03.15	2019.03.15	1. Нягтлан бодогч /хуучин/ 2. Эрх зүйн мэдээлэл захиргааны албаны дарга	1. Ч.Саранхүү 2. Б.Доржбат		
5	Зардал	5	"Шаргал Угалз" ХХК-тай 2018 оны 18/07 дугаартай хөшиг худалдан авах гэрээ хийсэн боловч гэрээний үнийн дүнгээс 0.1 сая төгрөг илүү шилжүүлсэн нэр бүхий 2 байгууллагатай хийсэн гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах тус гэрээг дүгнэсэн акт, тэмдэглэл үйлдэж байх.	0.1	Зөвлөмж өгсөн	2019.03.15	2019.03.15	1. Дарга 2. Нягтлан бодогч	1. Ж.Батсуурь 2. Д.Сэлэнгэ		
6	Орлого	1	Үндсэн үйл ажиллагааны орлого болох 0.9 сая төгрөгийг авлагаар тусгаагүй, 1.0 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй байна.	1.9	Зөвлөмж өгсөн	2019.03.15	2019.03.15	1. Нягтлан бодогч /хуучин/ 2. Нягтлан бодогч	1. Ч.Саранхүү 2. Д.Сэлэнгэ		
7	Авлага, өглөг	1	Нийт 41.2 сая төгрөгийн авлага, 0.5 сая төгрөгийн өглөгийг тус бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	41.7	Албан шаардлага өгөх	2019.03.15	2019.03.15	Нягтлан бодогч	Д.Сэлэнгэ		
8	Зардал	6	Нийт 2.2 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Үүнд тус зөвлөлийн даргын 2018 оны А/62 дугаар тушаалын үндэслэл алдаатай, автомашины торгуульд нийт 1.6 сая төгрөг, 2018 оны 18/12 дугаартай санхүүгийн тайлан гаргах тухай гэрээ байгуулан 0.2 сая төгрөг, АНУ-ын Сиатл хотод сургалтанд оролцох тухай тус зөвлөлийн даргын 2018 оны А/12 дугаар тушаал гарсан боловч тушаалаар олгосон мөнгийг буцаан тушааж визний зардал болох 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.	2.2	Албан шаардлага өгөх	2019.03.15	2019.03.15	1. Дарга /хуучин/ 2. Дарга 3. Нягтлан бодогч /хуучин/ 4. Нягтлан бодогч	1. Э.Пүрэвжав 2. Ж.Батсуурь 3. Ч.Саранхүү 4. Д.Сэлэнгэ		
9	Батлагдсан төсөв		Тус зөвлөл нь үйл ажиллагааны 2018 оны батлагдсан төсөвгүй 124.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үйл ажиллагааны 2018 оны төсвийг Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны 107 дугаар тогтоолоор батлуулсан байна.	124.1	Албан шаардлага өгөх	2019.03.15	2019.03.15	1. Дарга /хуучин/ 2. Нягтлан бодогч /хуучин/	1. Э.Пүрэвжав 2. Ч.Саранхүү		

